



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 3/11

Баянтал сум

Л.Отгонпүрэвт урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус сумын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн явуулж, сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг хууль тогтоомжид заасан хугацаанд стандартын дагуу үнэн зөв гаргаж, 2021 оны сумын нэгтгэсэн жилийн эцсийн тайланд хийсэн Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дүгнэлтээр УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн шударга илэрхийлэгдэж “Зөрчилгүй” санал дүгнэлттэй ажилласан Санхүү албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Отгонпүрэвт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгосугай.

2.Урамшууллын зардлыг цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас гаргахыг Санхүү албаны нягтлан бодогч (Х.Ариунгуга)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

В.ГАНТУЯА



ГОВСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМИНЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 5/18

Баянтал сум

М.Ичинхорлоог ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулагын 79 дүгээр зүйлийн 79.1, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.2.4, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 166 дугаар тушаал “Ээлжийн амралтын олговор тооцох журам”-ын заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгч албан тушаалтай М.Ичинхорлоогийн 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх өргөдөл гаргасан тул 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зохих журмын дагуу ажил хүлээлцэхийг комисст үүрэг болгосугай.

Комиссын дарга:

Э.Буяントгох (Төрийн сангийн
мэргэжилтэн)

Гишүүд:

Н.Мөнгөнцэцэг (1 дүгээр багийн Засаг
дарга)

Нарийн бичгийн дарга:

Н.Сарантуяа (Аж ахуйн нярав)

3. М.Ичинхорлоотой холбогдох тооцоог хийж, ажил амралтын мөнгийг бодож олгохыг Санхүү албаны няглан бодогч (Х.Ариунгуга)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

В.ГАНТУЯА



ОВОСТУМБЭР АЙМАГ
БАЯНТА ۸ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 8/13

Баянтал сум

**Н.Мөнгөнцэцгийг Архив бичиг хэргийн
эрхлэгчийн ажлыг хавсруулан ажиллуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, . Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, Монгол улсын Засгын газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.2 хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ Нь:

1. Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгчийн албан тушаалд Нэргүйн Мөнгөнцэцгийг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн түр томилсугай
2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зохих журмын дагуу ажил хүлээлцэхийг комисст үүрэг болгосугай.

Комиссын дарга: Л.Отгонпүрэв (Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга)
Гишүүд: Н.Сарантуяа (Аж ахуйн нярав)
Нарийн бичгийн дарга: М.Бодьгэрэл (хууль эрх зүйн мэргэжилтэн)

3. Н.Мөнгөнцэцгийг архив бичиг хэргийн эрхлэгчийн ажлыг хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 2022 оны 04 дүгээр сар 11-ний өдрөөс эхлэн үндсэн цалингийн 40 хувиар тооцон сар бүр бодож олгохыг нягтлан бодогч /Х.Ариунгуга/-д зөвшөөрсүгэй.

4. Н.Мөнгөнцэцгийг нь ажилдаа хариуцлагатай хандаж, хууль тогтоомжийг чанд сахиж, төрийн албан хаагчийн ёс зүйг мөрдөж, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ДАРГА
B. ГАНТУЯА